



дэлхий рүү тэмүүлсэн 20 жил



2025 он
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

MSE:MLG

| www.mlholding.mn

АГУУЛГА

01

БИДНИЙ ТУХАЙ

Компанийн тухай	4
Хуулийн этгээдийн мэдээлэл	5
Эрхэм зорилго, Алсын хараа	6
Үнэт зүйлс	7
Группийн бүтэц	9
Группийн түүхэн замнал	10
Онцлох тоон үзүүлэлтүүд	12
Онцлох үйл явдал	13
Онцлох тээвэр	14

02

ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН СТРАТЕГИ

Тээвэр ложистикийн салбар	16
Монложистикс групп	17
Алсын хараа 2030	18
Бизнес модель	19
2030 стратеги	20
2025 оны зорилт	21



03

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Группийн орлого, ачааны хэмжээ ...	23
Импорт, экспортын хэмжээ	24
Группийн транзит тээвэр, гадаад ачаа тээврийн хэмжээ	25

04

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Employee Day 2025	27
Ажилтнуудын эрүүл мэнд	28
Урлагийн наадам	29
СЭЗИС-тай санамж бичиг	29



05

ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	31
Засаглалын бүтэц, үйл ажиллагаа ...	31
Төлөөлөн удирдах зөвлөл	32
Дотоод хяналтын тогтолцоо	33

06

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	36
Нэгтгэсэн санхүү байдлын тайлан	36
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	37
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	38



БИДНИЙ ТУХАЙ

I БҮЛЭГ

Компанийн тухай	4
Хуулийн этгээдийн мэдээлэл	5
Эрхэм зорилго, Алсын хараа	6
Үнэт зүйлс	7
Группийн бүтэц	9
Группийн түүхэн замнал	10
Онцлох тоон үзүүлэлтүүд	12
Онцлох үйл явдал	13
Онцлох тээвэр	14



КОМПАНИЙН ТУХАЙ

2005 онд Монгол Улсад тээвэр зуучийн үйлчилгээний нэгэн шинэ хуудсыг эхлүүлж, цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан Монложистикс Групп нь өнөөдөр 20 жилийнхээ ойн босгон дээр 1 толгой компани, 10 охин компани, 240 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп болон өргөжин тэлжээ. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхий эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр ирлээ. 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажилласан бөгөөд энэ хугацаанд бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай групп компанийг бий болгожээ. Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:

Монложистикс Холдинг ХК

Хэлбэр:

Нээлттэй хувьцаат компани

Регистрийн дугаар:

6381251

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл:

**Менежментийн зөвлөх үйлчилгээ, төсөл
хөтөлбөр хэрэгжүүлэх**

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Монголын Хөрөнгийн Бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн индекс:

Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20

Монголын Хөрөнгийн Бирж дээрх симбол:

MSE:MLG

Утас:

+976 7701-5454

Имэйл:

info@mlholding.mn


Вэбсайт:

www.mlholding.mn

Фэйсбүүк хуудас: **Monlogistics Group**

Албан ёсны хаяг:

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс
оффис, 1101 тоот**



ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.



Шударга, ил тод байдал


Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан **2025**



ГРУППИЙН БҮТЭЦ



ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн
нэгдсэн холбоонд албан
ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН

Монгол Улсын Гаалийн
ерөнхий газраас Гаалийн
зуучлагчийн тусгай
зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding
“Upgrade 10” төслийг
амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монложистикс Ворлдвайд ХХК
анхны ууган компани
байгуулагдав.

2009 ОН

Төмөр замын аюулгүй
ажиллагааны тусгай
зөвшөөрлийг хүлээн авав.

2011 ОН

Монголын гаалийн
зуучлагчдын
нэгдсэн холбооны
гишүүнээр элсэв.

2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын
чанарын удирдлагын
тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Каус Аустралис ХХК-ийг байгуулав.



CORE системийн шинэчлэл хийгдэв. Группт 3 шинэ охин компани нэмэгдэв.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2024 ОН



2017 ОН

2019 ОН

2021 ОН

2023 ОН

2025 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

Монложистикс Холдинг ХК Do good HUB ТББ-ыг байгуулав.

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой





ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Импортын тээврийн өсөлт

^ **+21%**

Нийт хөрөнгийн өсөлт

^ **+18%**

Татварын дараах ашгийн өсөлт

^ **+14%**

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг
бүрэн зарцууллаа


**10.985 тэрбум
төгрөг**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монложистикс Групп 1 цуваа бүхий 50 ширхэг хөдлөх бүрэлдэхүүнтэй боллоо.

Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийх IPO-н төлөвлөгөөний дагуу ОХУ-аас худалдан авсан эхний ээлжийн вагонуудаа 2024 оны 12-р сард амжилттай хүлээн авсан бол дараагийн ээлжийн 40 ширхэг вагоныг 2025 оны 6-р сард хүлээж авлаа. Ийнхүү 1 цуваа буюу 50 ширхэг хөдлөх бүрэлдэхүүнтэй болсноор Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтэд оролцоход чухал ач холбогдолтой үйл явц болж байна.



Cheerah ТАОБАО-тай албан ёсоор холбогдлоо.

Монложистикс Группийн охин компани болох Монложистикс Карго компанийн онлайн худалдааны платформ Cheerah нь БНХАУ-ын хамгийн том худалдааны платформ болох ТАОБАО-тай албан ёсны холболтыг 2025 оны 5-р сард амжилттай хийж гүйцэтгэлээ. Cheerah 2.0 хөгжүүлэлтийн хүрээнд зөвхөн захиалгын хурд, брэндийн сонголт, төлбөрийн шийдлүүдийг сайжруулаад зогсохгүй, Монголдоо хамгийн хямд, Taobao холболттой e-commerce платформ болж чадсанаараа онцлогтой.



Тяньжин РТ Ложистикс ХХК-ийн бизнес түншлэл амжилттай эхэллээ.

Монложистикс Группийн охин компани болох Тяньжин РТ Ложистикс компанийн гол зорилго нь БНХАУ-аас болон гуравдагч орнуудаас ирж буй Монгол Улсын импортын тээврийг илүү хурдан, хямд, хүртээмжтэй болгох явдал юм. Тяньжин РТ Ложистикс компани нь энэ зорилгынхоо хүрээнд дэлхийн хамгийн том ачаа тээврийн компаниудын нэг болох COSCO групп болон Хятад-Солонгосын чиглэлийн далайн тээврийн анхны компани EAS-тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бизнес түншлэлийн эхний алхамуудаа амжилттай эхлүүлээд байна.



Хувьцаа халааслах хөтөлбөр хэрэгжиж байна.

“Монложистикс Холдинг” ХК нь хувьцааныхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсэн билээ. Энэ хүрээнд нийт 4,800,000 ихгүй, ширхэг хувьцааг нэг бүрийг нь 210 төгрөг хүртэл үнээр тооцон, нийт 1,008,000,000 төгрөг хүртэл үнийн дүнгээр хувьцааг худалдан авах ажиллагааг амжилттай хэрэгжиж байна. Хувьцааны эргүүлэн худалдан авалт нь 2025 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

ОНЦЛОХ ТЭЭВЭР



Монложистикс Тракинг ХХК

Монложистикс Тракинг ХХК нь 2025 оны 5-р сард Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт баригдаж буй Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцад суурилуулах трансформаторыг амжилттай тээвэрлэж, хүлээлгэн өглөө. Уг ачаа нь хэт хүнд, овор ихтэй, эмзэг ачаа бөгөөд тээвэрлэлтийн хурд, доргилт мэдрэгчтэй тул тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалалтын автомашинаар дагалдуулан тээвэрлэсэнээрээ онцлогтой юм.



Монложистикс Ворлдвайд ХХК

Монложистикс Ворлдвайд ХХК нь “Алт шингээх зориулалттай идэвхжүүлсэн нүүрс”-ийг БНЭУлсаас БНХАУ-ын Тяньжин хотын Синганг боомтоор дамжуулан тээвэрлэж, 2025 оны 6-р сард Говь-Алтай аймгийн Бигэр суманд амжилттай хүргэлээ. Мөн 2025 оны 6-р сард бетон зуурмагийн үйлдвэрийн эд анги, тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-аас зургаан ширхэг бүтэн машинаар амжилттай тээвэрлэж гүйцэтгэлээ.



Монложистикс Экспресс ХХК

Монгол Улс, Унгар Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ой 2025 онд тохиож, ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан үзэсгэлэнд тавигдах бүтээлүүдийг Монложистикс Экспресс компани агаараар амжилттай тээвэрлэлээ. Монголын театрын урлаг, өв соёлыг олон улсад сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, таниулах зорилгоор Унгар улсын нийслэл Будапешт хотноо зохион байгуулагдсан МИТЕМ театрын наадамд УДЭТеатрын хамт олон “Тэнгэрийн хүү” түүхэн туульсын жүжгээрээ оролцсон бөгөөд жүжгийн бүхий л хэрэгслүүд, ачааг Монложистикс Экспресс компани тээвэрлэсэн юм.



Монложистикс Экспресс ХХК

Монложистикс Экспресс ХХК нь БНСУ болон Монгол Улсын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах төслийн ачааг 2025 оны эхний хагас жилд агаарын тээврээр амжилттай хийж гүйцэтгэлээ.



ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН СТРАТЕГИ

II БҮЛЭГ

Тээвэр ложистикийн салбар	16
Монложистикс групп	17
Алсын хараа 2030	18
Бизнес модель	19
2030 стратеги	20
2025 оны зорилт	21

ДЭЛХИЙН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

2025 оны эхний хагаст олон улсад өрнөсөн геополитикийн зөрчил, худалдааны шинэ бодлогууд зэрэг нь тээвэр ложистикийн салбарт шинэ сорилт хүндрэлүүдийг авчрахын зэрэгцээ салбарын шинэчлэл, дижитал шилжилт эрчимтэй өрнөхөд томоохон түлхэц боллоо.

Тухайлбал 2025 оны эхээр худалдааны хөлөг онгоц руу халдах явдал дахин сэргэж, Maersk зэрэг томоохон тээврийн компаниуд Африкийн өмнөд эргээр тойрч зорчихоос өөр аргагүйд хүрэв. Улмаар тээвэрлэлтийн хугацаа дунджаар 10-14 хоногоор нэмэгдэж, далайн ачаа тээврийн үнэ 30-40%-аар өсөх шалтгаан болов.

Үүнээс гадна 2025 оны 2 дугаар сард АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трампын бусад улс орнуудад тавьсан худалдааны өндөр тарифын улмаас Лос Анжелес (Long Beach Port) боомтын импорт 9%-аар буурсан бол 4 дүгээр сард БНХАУ-аас АНУ руу чиглэсэн контейнерын хэмжээ 30-40%-аар багассан үр дагаврыг авчрав. Үүнээс үүдэн далайн тээврийн захиалга 25%-аар буурахын зэрэгцээ авто тээврийн салбарын ачаа эргэлт ч мөн 16-25%-аар багассан байна.

Мөн ОХУ, Украины дайн, АНУ, БНХАУ-ын худалдааны хориг зэргээс гадна Ойрх Дорнод дахь Израйл, Иран болон Энэтхэг, Пакистан зэрэг улс гүрнүүдийн хоорондын зөрчил хурцадсан нь дэлхийн газрын тосны зах зээлд хүчтэй нөлөө үзүүлж, Brent төрлийн газрын тосны үнэ 10%-аар буюу нэг баррель нь 73 ам.долларт хүрсэн нь дэлхийн нийт тээврийн зардлыг нэмэгдүүлэх бас нэгэн шалтгаан боллоо.

Гэхдээ энэ бүх учирсан сорилт, хүндрэлүүд нь дэлхийн тээвэр, ложистикийн салбарт инновац, шинэ техник, технологи нэвтрүүлэх гол хурдасгуур байлаа. Судалгаагаар тээвэр, ложистикийн компаниудын 70% нь хиймэл оюун ухаанд суурилсан системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж, маршрутын оновчлол, бараа хяналт, агуулахын менежментийг автоматжуулсан байна. Үүний зэрэгцээ газрын тосны үнийн өөрчлөлттэй холбоотойгоор байгаль орчны сөрөг нөлөө багатай шийдлүүд болох цахилгаан болон бага нүүрстөрөгч ялгаруулдаг тээврийн хэрэгсэл түлхүү ашиглах болж, ачааны чиглэл оновчлох AI систем зэргийг өргөнөөр нэвтрүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН САЛБАР

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Монгол Улсын тээвэр ложистикийн салбарт томоохон дэвшил авчрах зарим төсөл хөтөлбөрүүд 2025 оны эхний хагас жилд урагш алхлаа.

Тухайлбал, Гашуунсухайт-Ганцмод боомтыг төмөр замаар холбох Монгол Улс, БНХАУ-ын Засгийн Газар хоорондын хэлэлцээрийг 2025 оны 02 дугаар сарын 14-нд байгуулж, 05 дугаар сарын 14-нд бүтээн байгуулалтын ажлыг албан ёсоор эхлүүллээ. Монгол Улсын Засгийн Газрын тооцоолж байгаагаар тус боомтын төмөр замын барилга угсралтын ажил 2027 онд дуусах бөгөөд энэхүү төмөр зам холбогдсоноор боомтын хүчин чадал 2 дахин нэмэгдэж, нүүрсний экспорт 165 сая тоннд хүрэх, улмаар жилд 1.5 тэрбум ам.долларын орлого олох боломжтой болох юм.

Түүнчлэн Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замыг барих тухай Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний 21 дүгээр тогтоол тогтоол гарч, барилгын ажил 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэв. Ингэснээр Улаанбаатар хотын ачаа тээврийн терминалуудыг Хөшигийн хөндий рүү шилжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, ачаа эргэлтийг хурдасгах, өртөг зардлыг бууруулах олон давуу талууд бий болно гэдэгт итгэлтэй байна.



МОНЛОЖИСТИКС ГРУПП

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа - 2050”, дунд хугацааны хөгжлийн “Шинэ сэргэлтийн бодлого” болон Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад холбогдох бодлого чиглэлтэй уялдуулан Монложистикс Группийн хувьд төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний баазыг бий болгох, дээрх хөгжлийн төлөвлөгөөнүүдийг угтан өөрсдийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, ирээдүйд үүсэх боломжийг ашиглах зорилтыг 2025 онд дэвшүүлсэн.

Үүний нэг нь багагүй хугацаанд судалгаа хийж, хүчин чармайлт зарцуулан худалдаж авсан бидний цоо шинэ ачааны вагонуудын хоёрдугаар ээлж буюу 40 ширхэг хагас вагон үйлдвэрлэгдэн бэлэн болж, энэ оны зургаадугаар сард Монгол Улсад тээвэрлэгдэн ирлээ. Группийн хувьд уг вагонуудыг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, тэр дундаа Монгол Улсын нийгэм-эдийн засагт чухал нөлөө бүхий “Оюутолгой” ХХК-ийн зэсийн баяжмалыг төмөр замаар анх удаагаа тээвэрлэн гуравдагч зах зээлд гаргах ажилд ашиглахаар төлөвлөөд байна.

Үүний зэрэгцээ Монложистикс Группийн хувьд дижитал шилжилтийн төслүүдээ амжилттай үргэлжлүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хагас жил болж өнгөрөв. Тухайлбал, хэрэглэгч, харилцагчиддаа илүү хялбар үйлчилгээг санал болгохоос гадна цаг хугацаа хэмнэх, мэдээллийн найдвартай байдалд чиглэсэн чатбот буюу хиймэл оюунд суурилсан үйлчилгээг туршиж, нэвтрүүлж эхэллээ. Ингэснээр хүний хүчин зүйлээс шалтгаасан аливаа алдааг багасгаж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтанд эерэг үр дүн авчирна гэж бид итгэж байгаа юм.

2024 оны 12 сард олон улсын зах зээлд шинээр байгуулагдсан Монложистикс группийн отгон охин компани Тяньжин РТ Ложистикс ХХК анхны захиалгуудаа авч, үйл ажиллагаагаа эхлүүлсний зэрэгцээ Бүгд Найрамдах Солонгос Улсад үйл ажиллагаагаа эхлүүлэх талаар судалгаа, хөгжүүлэлтийг эрчимтэй хийж, тус улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэх компаниудтай уулзалт зохион байгуулах, боломжит бизнесийн боломжуудыг ашиглахад чиглэсэн олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



АЛСЫН ХАРАА 2030

Бид орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж улмаар Монгол Улсыг Ази, Европыг холбосон ложистик төв болгоно.

Уг алсын харааг биелүүлэх урт хугацааны стратеги, зорилгын хүрээнд дараах ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



БИЗНЕС МОДЕЛЬ

Олон улсад нийлүүлэлтийн сүлжээг удирдах хэлбэр 1PL загвараас 5PL хүртэл хөгжөөд буй бөгөөд Монложистикс Группийн хувьд өөрийн харилцагч байгууллагуудын ачааг тээвэрлэх тээврийн шинэ маршрутыг хөгжүүлснээр геополитикийн хүндрэлээс үүсэж буй тээвэрлэлтийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, хамтран ажиллагч түншийн харилцаа болон дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр тээвэрлэлтийн хямд бөгөөд хурдан шуурхай үйлчилгээг санал болгож, өөрийн 3PL бизнес моделийг хөгжүүлэн ажиллаж байна.

3PL загвар нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний олон асуудлыг хариуцдаг мэргэжлийн ложистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниас Ачааг хүлээн авах, Тээвэрлэх, Хадгалах, Савлах, Шошголох, Хүргэлт хийх гэх мэт үйлчилгээг авч байгаа хэлбэр юм. 3PL үйлчилгээ үзүүлэгчид нь илгээгч болон тээвэрлэгчдийн хооронд зохион байгуулагчийн үүрэг гүйцэтгэж, үр ашгийг оновчтой болгох, зардлыг бууруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн гинжин хэлхээний ложистикийг удирддаг. 3PL үйлчилгээ үзүүлэгч компаниудын үйлчилгээг ашигласнаар бизнес эрхлэгчид үндсэн бизнестээ анхаарлаа төвлөрүүлж, ложистикийн хэрэгцээгээ туршлагатай мэргэжилтнүүдэд даатгаж чаддаг.



Бидний хувьд ачаа илгээгчээс хүрэх эцсийн цэг буюу ачаа хүлээн авагчид очих хүртэл тээвэр, ложистикийн бүхий л үйлчилгээг харилцагчдадаа санал болгодог. Үүнд тээврийн захиалга хүлээн авах, ачаа барааг илгээгчээс хүлээн авахаас өгсүүлээд агуулахын үйлчилгээ, баримт бичиг гаалийн бүрдүүлэлт хийх, ачааг тээврийн хэрэгсэлд ачих, бэхлэх, нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шуурхай шилжүүлэн ачих гэх мэт цогц үйлчилгээ багтдаг. Түүнчлэн олон улсад тээвэр ложистикийн үйл ажиллагаа эрхэлдэг нэр хүндтэй, туршлагатай түншүүдтэй хамтран эдгээр цогц үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ бүх ачааг эрсдэлээс хамгаалж, даатгалд хамруулдаг нь бидний давуу тал, онцлог юм.

Тээврийн цогц үйлчилгээ

Тээврийн захиалга авах – Ачаа барааг хүлээн авах – Агуулахад хадгалах – Баримт бичиг болон гаалийн бүрдүүлэлт хийх – Ачаа барааг бэхлэх – Худалдан авалтын менежмент – Тээврийн хэрэгсэл хооронд шуурхай шилжүүлэн ачих – Даатгал





2030 СТРАТЕГИ

Монложистикс Группийн бүтэц зохион байгуулалтын хүрээнд өсөлтийн 4 стратеги, тогтвортой хөгжлийн 4 стратегийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



2025 ОНЫ ЗОРИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2025 оны санхүүгийн төлөвлөгөө

Хүлээлт 2025 (тэрбум.төгрөг)	2024 гүйцэтгэл	2025 төлөвлөгөө
Цэвэр ашиг	10.3	13-14
Цэвэр ашгийн хувь	3.4%	3.4%

2025 оны санхүүгийн төлөвлөгөөний суурь таамаглал

Монложистикс Групп нь 2025 оны бизнес төлөвлөгөөнд эдийн засгийн өсөлтийн 6%, ам.долларын жилийн дундаж ханшийг 3559 төгрөг, Монгол Улсын ложистикийн салбарын өсөлтийг 19% байхаар төлөвлөсөн. 2025 онд Групп нь өсөлтийг импортын тээврийн төрлийг нэмэгдүүлж, эзэмшлийн вагонуудаа экспортын тээвэрт явуулж эхэлснээр бий болгохоор төлөвлөж байна. 2025 онд Монложистикс Группийн 20 жилийн ойг тохиолдуулан зах зээлд дэвшилтэт технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн танилцуулахаар бэлдэж байна.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн (сая.төгрөг)	Төлөвлөгөө	Зарцуулалт	Үлдэгдэл
1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт	8,062	4,562	3,500
2. Эргэлтийн хөрөнгө	2,923	2,923	0
3. Төв Азийн Зам ХХК		3,500	-3,500
Нийт	10,985	10,985	0

1. Хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт

Монгол Улсын Засгийн Газраас баримталж буй экспортыг нэмэгдүүлэх, төмөр замын суурь бүтцийн сүлжээг өргөжүүлэх бодлого чиглэлийн хүрээнд Монложистикс Групп нь бизнесийн үр ашгаа нэмэгдүүлэх, өрсөлдөөний давуу талуудыг бий болгох зорилгоор дэд бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний хөрөнгө оруулалт хийхээр 2 цуваа буюу 100 ширхэг 13-6953 загварын тавцант вагоныг ОХУ-аас худалдан авахаар төлөвлөсөн. Гэвч дотоод болон гадаад хүчин зүйлс, тухайлбал Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилт, дотоодын вагоны эрэлт хэрэгцээ мөн хөрш орны дайны нөхцөл байдал зэргээс шалтгаалан вагоны тоо ширхэг, хөрөнгө оруулалтын хугацаа болон вагоны төрөлд өөрчлөлт оруулахаар Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс шийдвэрлэсэн. Үүний дагуу ОХУ-аас 50 ширхэг 12-1293 загварын ачааны хагас вагон шинээр худалдан авах гэрээ байгуулж, эхний 10 вагон 2024 оны 12 дугаар сард, дараагийн 40 вагон 2025 оны 6 дугаар сард Монгол Улсад орж ирэн тээврийн үйл ажиллагаанд оролцож эхэллээ. Бид 50 ширхэг вагоны гэрээний төлбөрт 8 тэрбум төгрөг төлсөн бөгөөд үүний 4,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцууллаа.

2. Эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэлт

Охин компаниудын үйл ажиллагааг өргөжүүлэх, өсөлтийг дэмжих, стратеги төлөвлөгөөг хангахын тулд эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 2,9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулсан.

3. Шинэ бизнес: M&A - Төв Азийн Зам ХХК

Монложистикс Групп нь тээвэр ложистикийн салбарт үйл ажиллагаа нь жигдэрсэн, зах зээл дээр хэдийн байршсан компани худалдан авах замаар бизнесийн цар хүрээ, зах зээлд эзлэх байр сууриа тэлэхээр ТЭСО Группийн охин компани болох Төв Азийн Зам ХХК-ийг худалдан авах, хөрөнгө оруулах замаар хяналтын багц буюу 51%-ийг өөртөө нэгтгэсэн. Энэхүү хөрөнгө оруулалтад 3,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцууллаа.




БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

III БҮЛЭГ

Группийн орлого, ачааны хэмжээ ...	23
Импорт, экспортын хэмжээ	24
Группийн транзит тээвэр, гадаад ачаа тээврийн хэмжээ.....	25

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР /




2025 оны 2-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 18% буурсан байна.

“Эх сурвалж: ҮСХ-ийн мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно.”


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




Монложистикс Группийн нийт борлуулалтын орлого 142.4 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 0.4% өссөн үзүүлэлттэй байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



2025 оны 2-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлийн хэмжээ 59.5 сая.тн хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 5% буурсан байна.


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /



Монложистикс группийн ачаа эргэлт 377 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 34% буурсан үзүүлэлттэй байна.


ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ

/ МЯНГАН ТОННООР /





ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

IV БҮЛЭГ

Employee Day 2025.....	27
Ажилтнуудын эрүүл мэнд.....	28
Урлагийн наадам	29
СЭЗИС-тай санамж бичиг	29

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Монложистикс групп нь тогтвортой хөгжлийн стратеги, ажилтан төвтэй хүний нөөцийн бодлого, группийн үнэт зүйлсийн хүрээнд 2025 оны эхний хагас жилд группийн нийт ажилтнуудынхаа эрүүл мэнд, сургалт хөгжил, багийн ажиллагаа, бүтээмжийн өсөлтийг дэмжсэн олон арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

EMPLOYEE DAY-2025 ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Ажил олгогчийн брэндингийг дотооддоо таниулах замаар нийт ажилтнуудын сэтгэл ханамжтай, бүтээмж өндөр, тогтвортой ажиллахад нөлөөлж, нээлттэй хувьцаат компанийн ил тод байдалд тулгуурлан, зах зээлийн тэргүүлэгч байгууллагын бизнесийн алсын харааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ажилтан бүрийн оролцоог нэмэх зорилгоор Монложистикс Групп нь 5 дахь жилдээ “EMPLOYEE DAY” арга хэмжээг 2025 оны 6-р сард “Бүтээлч хамт олон” уриан дор 7 өдрийн турш амжилттай зохион байгуулагдлаа.

Группийн хэмжээнд зохион байгуулсан “Employee Day-2025” арга хэмжээний нээлтийн өдөр бид группийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, 2030 он хүртэлх стратегийн хүрээ, 2025–2026 оны гол зорилтууд, хэрэгжиж буй төслүүд болон тэдгээрийн үр дүнг хамт олонтойгоо хуваалцан, тэдний санал бодлыг сонсож, харилцан ойлголцол, итгэлцлийг гүнзгийрүүлсэн ач холбогдолтой арга хэмжээг зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Ондо ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Мандуул өөрийн карьерын замнал, амжилт ба сорилт, ирээдүйн зорилго төлөвлөгөөний тухай чөлөөт ярилцлага өрнүүлж, Дэйл Карнеги Трейнинг Монгол төвийн сургагч багш А.Даваасүрэн багийн ажиллагаа, бүтээмжийн чиглэлийн сургалтаар ажилтнуудад мэдлэг, туршлагаа хуваалцсан юм.



Арга хэмжээний дараагийн өдрүүдэд ажилтан бүрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ мэдлэг туршлага хуримтлуулахад чиглэсэн сургалт, хэлэлцүүлгүүд, урам зориг өгөх зочдын оролцоотойгоор өрнөлөө. Тухайлбал: Санхүүгийн зөвлөх, хөрөнгө оруулалтын аналит, зохиолч А.Идэрбат санхүүгийн боловсрол, хөрөнгө оруулалтын сэдвээр сонирхолтой, хэрэгцээтэй сургалт явуулж, ажилтнууд группийн хэмжээнд хэрэгжиж буй ESOP хөтөлбөрт хамрагдаж, урт хугацааны хуримтлалтай болохын давуу талыг бататгаж өгсөн. “Бүтээмжийг бүүслэе” уриатай эрүүл мэндийн өдөр: Сэтгэл Судлалын Үндэсний Төв ТББ-ын Гүйцэтгэх захирал, сэтгэл судлаач Б.Ууганцэцэг “Сэтгэл зүйн эрүүл байдал, амьдралын чанар” сэдвээр; Мэргэшсэн хоол зүйч С.Мөнхцэцэг “Эрүүл зөв хооллолт”-ын талаар мэдлэг олгож, ажилтнуудтай илэн далангүй ярилцлаа. Ажилтнууд MLC Business School-ийн “TALENT BOX” хөтөлбөрт хамрагдаж, хувийн бүтээмжээ нэмэгдүүлэх практик арга барилд хамруулсан нь арга хэмжээний үр өгөөжийг улам нэмэгдүүлсэн юм.

БҮХ АЖИЛТНУУДЫГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛЛАА.

Нийт ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой зохион байгуулсан эрүүл мэндийн үзлэгт Монложистикс Группийн нийт ажилтнууд 2025 оны 3-р сарын 15-наас 5-р сарын 15-ны хооронд Интермэд эмнэлэгт багц шинжилгээнүүд, дурангийн болон бусад нарийн мэргэжлийн үзлэгүүд хийлгэж, эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээнд хамрагдлаа. Эрүүл мэндийн үзлэг нь ажилтнуудын амьдралын чанар, ажлын бүтээмжийг дэмжих, аливаа өвчнийг эрт үед нь илрүүлэх, эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилготой, компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлогын нэг хэсэг юм.



УРЛАГИЙН НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Ажилтнуудын авьяасыг нээн хөгжүүлэх, оролцоо, бүтээлч байдал, багийн ажиллагааг дэмжих зорилготой Монложистикс Группийн “Урлагийн Их Наадам” амжилттай зохион байгуулагдаж, группийн 200 гаруй ажилтнууд нийт 6 багт хуваагдан авьяас чадвар, бүтээлч багийн ажиллагаа, эрч хүчээрээ өрсөлдсөн юм. Гурван жилд нэг удаа зохион байгуулагддаг “Урлагийн Их Наадам” нь энэ удаад Монложистикс Групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг угтан зохион байгуулсан онцлог нэгэн арга хэмжээ боллоо.



СЭЗИС-ТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА.

2025 оны 6-р сарын 17-ны өдөр Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) болон Монложистикс Холдинг ХК-ийн хооронд судлаач багш, оюутны хөгжил, салбарын хүний нөөцийн чадавх, судалгаа, сургалтын чиглэлд хамтын ажиллагааг өрнүүлэх зорилго бүхий санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус хамтын ажиллагааны хүрээнд:

- ♦ Хүний нөөцийг харилцан чадавхжуулах, ажилтны ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамтран ажиллах;
- ♦ СЭЗИС-ийн тэргүүлэх судлаачдад зориулсан байгууллагын нэрэмжит грант олгох;
- ♦ СЭЗИС-ийн бакалаврын түвшний оюутнуудад зориулсан дадлагажих, ажлын байранд бэлтгэгдэх боломж олгох;
- ♦ Чанартай боловсролыг дэмжих хүрээнд сургалтын төлөвлөгөө, арга зүйг сайжруулах, зочин илтгэгч, лекцүүд зохион байгуулах;
- ♦ Монгол улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн брэнд бүтээх уралдаан, нөлөөллийн эвентүүд зохион байгуулах;
- ♦ Судалгаа, хөгжлийн хамтарсан төсөл, мэдлэгийг хуваалцах платформ бий болгох зэргээр компанид төдийгүй салбартаа чухал ач холбогдолтой үйл ажиллагаанууд хийгдэх юм.





ЗАСАГЛАЛ

V БҮЛЭГ


Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	31
Засаглалын бүтэц, үйл ажиллагаа ...	31
Төлөөлөн удирдах зөвлөл	32
Дотоод хяналтын тогтолцоо	33

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Хувьцаа эзэмшигчдийн тоо:



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

I. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монложистикс Холдинг ХК-ийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 87.74%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулагдсан. Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар олон нийтэд хүргэсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлахын өмнө компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг товч танилцуулж;
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог компанийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тус тус танилцуулж, хувьцаа эзэмшигчдээс ирсэн асуултанд хариулж оролцсон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар:

1. Монложистикс Холдинг ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батласан.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Лувсанжамба
ГАНЗОРИГТ**

Үүсгэн байгуулагч
ба ТУЗ-ийн дарга

Санхүү, олон улсын худалдааны
чиглэлээр 31 жилийн
туршлагатай.



**Бааст
ТЭЛЭНГЭД**

Үүсгэн байгуулагч, ТУЗ-
ийн ердийн гишүүн

Тээвэр ложистикийн салбарт 31
жилийн туршлагатай.



**Өлзийбаяр
ГАНЗОРИГ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
23 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



**Ганзоригт
ХИШИГБАТ**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Санхүү, хөрөнгө оруулалтаар
11 жил, засаглал удирдлагын
чиглэлээр 8 жилийн
туршлагатай.



**Балдан
ЭНХТҮВШИН**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Банк, санхүү, даатгалын салбарт
21 жилийн засаглал, гүйцэтгэх
удирдлагын туршлагатай.



**Эрэндоо
ОЮУНБИЛЭГ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Банк санхүүгийн салбарт 31
жилийн компанийн засаглалын
мэргэшсэн туршлагатай.



**Санжаа
САЙНБАТ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Худалдаа үйлчилгээний салбарт
засаглал удирдлагын чиглэлээр
21 жилийн туршлагатай.



**Готов
ЦЭРЭНПҮРЭВ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Олон улсын банк санхүүгийн
салбарт 41 жилийн удирдах
чиглэлийн туршлагатай.



**Сэнгээ
ЭНХ-АМГАЛАН**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

Бизнесийн удирдлага, засаглал,
гүйцэтгэх удирдлагын 23
жилийн туршлагатай.



Цогт ДУЛАМСҮРЭН

ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга бөгөөд Нийцэл
хариуцсан ажилтан

Хүний нөөц, захиргаа, эрх
зүй, засаглалын 21 жилийн
туршлагатай.

II. Төлөөлөн удирдах зөвлөл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл юм. Хурдацтай өөрчлөгдөж буй бизнесийн талбарт үүсч болох эрсдэл ба боломжийг амжилттай удирдах чадвартай, салбар салбартаа мэргэшсэн, туршлагатай гишүүдээс Монложистикс Холдинг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл бүрддэг бөгөөд ердийн 5, хараат бус 4, нийт 9 гишүүнтэй.

III. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн хурал

Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ нь 2025 оны эхний хагас жилд ээлжит болон ээлжит бус нийт 4 удаагийн хурал зохион байгуулж, гишүүд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд хурлын дундаж ирц 96%. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ТУЗ-ийн хурал болон ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт явуулах замаар 2025 оны эхний хагас жилд ТУЗ-өөс нийт 32 тогтоол шийдвэрийг баталсан.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2025 оны эхний хагас жилд биечлэн болон цахим хэлбэрээр нийт 8 удаа хуралдаж, хороодын ажлын чиг үүргийн дагуу идэвх санаачлагатай ажиллаж байна.

IV. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

Монложистикс Холдинг ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа нийт хувьцаа компаниудиаас “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 97,2%-ийн үнэлгээтэйгээр, эзлүүлсэн байр буюу засаглалын зэрэглэлээр 2024 онд 2-р байрт, Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанийн нэгээр шалгарсан билээ. Бид 2025 оны эхний хагас жилд засаглалын дүрэм журмын сайжруулалтын хүрээнд “Ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн баталсан бөгөөд “Компанийн засаглалын кодекс”-ийн өөрийн үнэлгээг хийж, Санхүүгийн Зохицуулах Хороо-д илгээлээ.

V. Хяналт

Монложистикс Групп нь “Гурван шугамын загвар”-ын зарчмаар дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, үйл ажиллагааны бүхий л шатанд хяналтыг чиг үүргийнхээ дагуу дараах байдлаар хэрэгжүүлэн ажилладаг.

Дотоод хяналтын тогтолцооны гурван шугамын загвар



Монложистикс Группийн бизнесийн үйл ажиллагааг эрсдэлгүй, тогтвортой явуулахад хяналтын тогтолцооны хүрээнд анхаарч, 2025 оны эхний хагас жилд дараах чиглэлээр хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Компанийн засаглал, мөрдөгдөж буй дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийн нийцлийг үнэлэх, зөвлөмж өгөх нийцлийн аудит;
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO стандартын хэрэгжилтийг үнэлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй байдлыг хангах, сайжруулах боломжийг тодорхойлох ISO дотоод аудит;
- ТУЗ-ийн дэргэдэх хараат бус дотоод аудит;

VI. Ногдол ашиг тараалаа

Монложистикс Холдинг ХК нь 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 21.9% /хорин нэг аравны ес/ хувь буюу 2,137,637,638.80 /хоёр тэрбум нэг зуун гучин долоон сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун гучин найман төгрөг наян мөнгө/ төгрөгийг Компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн. Нэгж хувьцаа тус бүрд 5.40 /таван төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар зарласан бөгөөд ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосон. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан олголоо.

VII. Хувьцаа халааслах хөтөлбөр

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь 4,8 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь 210 төгрөгөөр үнэлж нээлттэй зах зээлд дээрээс эргүүлэн худалдаж авахаа зарласан билээ. Хувьцаагаа халаасалсны үр дүнд хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, өсөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 394,564,897 (гурван зуун ерэн дөрвөн сая таван зуун жаран дөрвөн мянга найман зуун ерэн долоо) төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг нээлттэй зах зээлээс эргүүлэн худалдаж аваад байна.





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

V БҮЛЭГ

Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	36
Нэгтгэсэн санхүү байдлын тайлан	36
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	37
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	38

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2023 Н1	2024 Н1	2025 Н1
Борлуулалтын орлого	91,497	141,982	142,397
Борлуулалтын өртөг	(82,663)	(130,264)	(130,038)
Нийт ашиг	8,834	11,718	12,359
Борлуулалт, Удирдлагын зардал	(3,421)	(4,156)	(5,197)
Бусад орлого	(178)	177	2,961
Бусад зардал	(17)	(176)	(514)
Үйл ажиллагааны цэвэр ашиг	5,218	7,562	9,608
Санхүүгийн орлого (зардал)	(58)	27	(843)
Татварын өмнөх цэвэр ашиг (ЕВТ)	5,160	7,590	8,766
ОАТ-н зардал	(583)	(943)	(1,208)
Цэвэр ашиг	4,577	6,646	7,557
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	3,405	4,993	5,211
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,172	1,653	2,347
Бүх дэлгэрэнгүй орлого			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	24	350
Бусад дэлгэрэнгүй орлогын олз (гарз)	-	-	2,034
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	4,577	6,670	9,942
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	3,405	5,017	7,595
Хяналтын эрхгүй хувь оролцоо	1,172	1,653	2,347
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	4,577	6,670	9,942

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2023 Н1	2024 Н1	2025 Н1
Мөнгөн хөрөнгө	8,742	9,194	8,488
Дансны авлага	25,754	39,475	44,191
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	3,195	436
Урьдчилж төлсөн төлбөр	7,757	19,314	10,018
Бараа материал	151	3,622	19,198
Бусад эргэлтийн хөрөнгө		2,294	2,304
Эргэлтийн хөрөнгө	42,404	77,093	84,636
Үндсэн хөрөнгө	1,639	1,902	14,697
Ашиглах эрх бүхий хөрөнгө	1,648	836	3,463
Бусад эргэлтийн бус хөрөнгө	56	2,629	1,442
Гудвилл	-	3,463	-
Эргэлтийн бус хөрөнгө	3,343	8,830	19,602
Нийт хөрөнгө	45,747	85,923	104,237
Дансны өглөг	10,391	20,725	18,986
Урьдчилж орсон орлого	1,291	8,646	6,610
Богино хугацаат зээл	2,754	4,642	12,011
Бусад өглөг	486	1,250	6,337
Богино хугацаат өр төлбөр	14,923	35,263	43,945
Урт хугацаат өр төлбөр	1,684	2,905	7,029
Нийт өр төлбөр	16,606	38,168	50,974
Эздийн өмч	26,237	41,604	45,638
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	2,904	6,150	7,626
Нийт Эздийн өмч	29,141	47,754	53,264
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	45,747	85,923	104,237

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлангийн үзүүлэлт	2023 Н1	2024 Н1	2025 Н1
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн	85,407	184,318	148,687
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	84,100	140,313	137,372
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	21
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	72	44
Буцаан авсан албан татвар	-	926	903
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	14
Бусад мөнгөн орлого	1,307	43,007	10,333
Мөнгөн зарлагын дүн	91,425	196,181	150,058
Ажиллагчдад төлсөн	2,953	1,039	5,369
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	378	756	1,186
Бараа материал худалдан авахад төлсөн	-	7,891	53,647
Ашиглалтын зардалд төлсөн	4	110	198
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	74,354	101,139	77,473
Хүүний төлбөрт төлсөн	81	100	371
Татварын байгууллагад төлсөн	2,159	4,838	4,013
Даатгалын төлбөрт төлсөн	7	145	205
Бусад мөнгөн зарлага	11,490	80,163	6,628
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,018)	(11,863)	(1,371)

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	124	8,194	4,983
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	8	20
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	65	5,225	4,153
Хүлээн авсан хүүний орлого	59	2,909	809
Хүлээн авсан ногдол ашиг	-	53	-

	2023 Н1	2024 Н1	2025 Н1
Мөнгөн зарлагын дүн			
Мөнгөн зарлагын дүн	24	17,444	7,643
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15	262	3,185
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	3,856	1,254
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	34	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	9	9,711	3,204
ХО бусад мөнгөн зарлага	-	3,580	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	99	(9,250)	(2,660)

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн	2,348	29,876	35,529
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,348	28,576	35,337
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	1,000	193
Төрөл бүрийн хандив	-	0	(1)
Бусад санхүүгийн мөнгөн орлого	-	300	-
Мөнгөн зарлагын дүн	1,802	21,610	32,011
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,477	18,041	28,867
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	135	355	389
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-	723
Төлсөн ногдол ашиг	190	2,858	2,032
Бусад санхүүгийн мөнгөн зарлага	-	355	-

Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	546	8,266	3,519
Валютын ханшийн зөрүү	(83)	(271)	291
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,456)	(13,118)	(220)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,198	22,312	8,709
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,742	9,194	8,488

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн үзүүлэлт (сая ₮)	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Хяналтын эрхгүй хувь оролцоо	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	119	-	10,188	(212)	29,191	4,154	43,439
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	11	52	22	85
Залруулсан үлдэгдэл	119	-	10,188	(200)	29,243	4,176	43,525
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	7,339	3,008	10,346
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(106)	-	-	(319)
Өмчид гарсан өөрчлөлт	-	(1,427)	-	-	329	342	(757)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,945)	(1,200)	(4,145)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	119	(1,427)	10,188	(307)	33,965	6,325	48,650
Нягтлан бодох бүртгэлийн залруулга	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	119	(1,427)	10,188	(307)	33,965	6,325	48,650
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	5,211	2,347	7,557
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	350	1,046	(1,046)	2,384
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(2,017)	-	(2,017)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2025 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл	119	(1,427)	10,188	43	38,205	7,626	56,575



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454

www.mlholding.mn